# ХЭВЛЭЛИЙН БАГА ХУРАЛ

2020.06.12

# ОРХОН АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ 2020 ОНЫ 5-Р САРД

# АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ДҮН

**Эерэг үзүүлэлт:**

- Төсвийн орлого -18.1% өссөн.
- Нийгмийн даатгалын сангийн орлого – 17.9% өссөн.
- Барилга угсралт, их засварын ажил – 82.7% нэмэгдсэн.
- Худалдаа, нийтийн хоолны бараа гүйлгээ -2.6% нэмэгдсэн.
- Нийтийн аж ахуйн үйлчилгээний орлого – 12.2% өссөн.
- Эрүүл мэндийн нийт үзлэг – 0.1% нэмэгдсэн.
- Нас баралт- 0.1 промилээр буурсан.
- Халдварт өвчнөөр өвчлөгсөд -7.1 продицимилээр буурсан.
- Гэмт хэргийн гаралт – 14.7% буурсан.
- Гэмт хэргийн илрүүлэлт – 4.8 пунктээр өссөн.

**Сөрөг үзүүлэлт:**

- Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт – 20.6% буурсан.
- Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн борлуулалт – 15.3% буурсан.
- Ахуйн үйлчилгээний орлого – 4.7% буурсан.
- Авто тээврийн орлого -25.3% буурсан.
- Нийт бий болсон ажлын байр – 11.5% бага.
- Урьдчилан сэргийлэх үзлэг – 13.4% буурсан.
- Төрөлт-0.4 промилээр буурсан.
- Нялхсын эндэгдэл – 1.3 промилээр өссөн.
- Гэмт хэрэгт холбогдогч-12.8% нэмэгдсэн.

## АЖЛЫН БАЙР






Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгэлтэй ажил хайж бүртгүүлсэн иргэд 2020 оны 5-р сард **1.4 мянга** байгаа нь өмнөх оны мөн үеэс 10 (0.7%) хүнээр их байна.

2020 он




Нийт бүртгэлтэй ажилгүй иргэдийн **766 (54.6%) эмэгтэйчүүд байна.**

Тайлант хугацаанд бүртгэгдсэн ажилгүйчүүдийн 22.5 хувь нь сургууль төгссөн, 8.6 хувь нь өөр газраас шилжиж ирсэн, 5.5 хувь нь орон тооны цомхотголд орсон, 1.6 хувь нь байгууллага татан буугдсан, 61.8 хувь нь бусад шалтгаанаар ажил хайж бүртгүүлжээ.

## ЭРҮҮЛ МЭНД

### Нийт үзлэг



Эрүүл мэндийн байгууллагууд давхардсан тоогоор 272.8 мянган хүнд үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеэс 0.1хувиар нэмэгджээ.

### Урьдчилан сэргийлэх үзлэг




Нийт үзлэгийн 33.1 хувийг буюу 90.4 мянган хүнийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 13.4 хувиар буурчээ.

### ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ГАРАЛТ, *продицимилээр*



## ХЭРЭГ, ЗӨРЧИЛ

### БҮРТГЭГДСЭН ХЭРЭГ, тоо




### БҮРТГЭГДСЭН ХЭРЭГ, өнгөөр






Цагдаагийн газрын мэдээгээр 272 хэрэгт 167 хүн холбогдон шалгагдаж, хэргийн илрүүлэлт 48.1 хувьтай байна. Өмнөх оны мөн үеэс хэргийн илрүүлэлт 4.8 пунктээр, холбогдогч 12.8 хувиар их, бүртгэгдсэн хэрэг 14.7 хувиар, 18–аас дээш насны 10000 хүнд ногдох гэмт хэрэг 6.9 продицимилээр буурчээ.

# ТӨСӨВ

## ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА (тэрбум төгрөг)




## ТӨСВИЙН ЗАРЛАГА, *салбарын бүтэц, хувь*




Аймгийн төсөвт 50.1 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 107.7 хувьтай байна. Татварын орлогын төлөвлөгөө 19.3 хувиар даван биелж, татварын бус орлогын төлөвлөгөө 4.93 хувиар тасарчээ.

# АЖ ҮЙЛДВЭР

**БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ,** *(тэрбум төгрөг)*




**БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ,** *бүтцээр*






Аж үйлдвэрийн салбарт 733.1 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн, 779.1 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн борлуулж, өмнөх оны мөн үеэс үйлдвэрлэлт 20.6 хувиар, борлуулалт 15.3 хувиар буурчээ.

## ХУДАЛДАА, НИЙТИЙН ХООЛ

**БАРАА ГҮЙЛГЭЭ,** *сая төгрөг*




**БАРАА ГҮЙЛГЭЭ,** *бүтцээр, 2020 он*




Худалдаа, нийтийн хоолны 658 цэг салбар 51.4 тэрбум төгрөгийн бараа гүйлгээ хийж, бараа гүйлгээний нийт хэмжээ өмнөх оны мөн үеэс 2.6 хувиар нэмэгджээ.



# ГАЗАР ТАРИАЛАН

ТАРИАЛАЛСАН ТАЛБАЙ, га

| Үзүүлэлт | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 |
|---|---|---|---|---|---|
| Үр тариа | 3370.7 | 4231.0 | 3506.0 | 3819.5 | 3580.0 |
| Төмс | 238.7 | 272.2 | 276.7 | 203.7 | 300.2 |
| Хүнсний ногоо | 219.0 | 194.2 | 181.9 | 123.7 | 204.4 |

# БАРИЛГА, ОРОН СУУЦ



## БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ

*(тэрбум төгрөг)*




Тайлант хугацаанд их барилгын салбарт 35 аж ахуй нэгж 26.4 тэрбум төгрөгийн барилга угсралт, их засварын ажлыг 50 обьектод хийж гүйцэтгэсний 24.9 хувь нь их засварын ажил байна. Гүйцэтгэсэн ажлын дүн өмнөх оны мөн үеэс 82.7 хувиар нэмэгджээ.


WWW.1212.MN
СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН
Статистик
Мэдээ, мэдээлэл
Номын сан
Мэдлэгээ шалгах тоглоом
Валютын ханш
1212
аппликейшнаас
СТАТИСТИКИЙН мэдээллээ аваарай
Data lab
Social network
www.facebook.com/StatisticMongolia/
www.twitter.com/statistic_mn
Лавлах утас
1900-1212
Цахим шуудан
information@nso.mn

# АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА.